



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 05 сарын 01 өдөр

Дугаар 3/09

Хажуу шинэ ус

Д.Сарангэрэлийг ажилд томилох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.3, Засгийн газрын 2022 оны “Төрийн зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 488 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, Төрийн албаны зөвлөлийн Дундговь аймаг дахь салбар зөвлөлийн 2023 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн А/49 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Засаг даргын Тамгын газрын Хүнс, жижиг дунд үйлдвэр хоршооны асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд Дорждэрэмийн Сарангэрэлийг 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн томилсугай.

2. Д.Сарангэрэл-д Засгийн газрын 2022 оны “Төрийн зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 488 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын дагуу ТЗ-9 дахь шатлал 791,532.00 (Долоон зуун ерэн нэгэн мянга таван зуун гучин хоёр) төгрөгөөр тооцож ажилласан жил, зэрэг дэв, орон нутагт ажилласны нэмэгдлийг олгон цалинжуулахыг нягтлан бодогч (У.Сүнжидмаа)-д зөвшөөрсүгэй.

3.Албан үүргээ гүйцэтгэхдээ Авлигын эсрэг хууль болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хориглолт хязгаарлалтуудыг баримтлан, бусад хууль тогтоомж, ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргийг мэргэжлийн түвшинд чанартай гүйцэтгэж эрхэлсэн ажилдаа хариуцлагатай хандан, төрийн албан хаагчийн ёс зүй, санхүүгийн албаны чиг үүргийг хуулийн хүрээнд чанд сахин ажиллахыг (Д.Сарангэрэл)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Н.ӨЛЗИЙТОГТОХ

482305009